



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Жаргалант сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** ХОА-2026/007/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Ховд хот  
2026 он

Дарга, тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Утас: 99047408 Цахим хаяг: boldbaatarkh@audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 99013699 Цахим  
хаяг: tsetsegsurena@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Мөнхтулга

Утас: 99031809 Цахим хаяг: munkhtulgad@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ХОВД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд аймаг  
Утас/Факс: (976)-7043-3061  
Email: khovd@audit.gov.mn

2026.03.23 № 265

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ЖАРГАЛАНТ СУМЫН ЗАСАГ ДАРГА  
Б.АМАРТҮВШИН ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Жаргалант сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Жаргалант сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Жаргалант сумын 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд 29 төсвийн байгууллага, 2 тусгай сан нийт 31 байгууллага хамрагдсан байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Жаргалант сум нь татварын болон татварын бус орлогоор нийт 22,139.6 сая төгрөгийн орлого бүрдүүлж, орлогыг 564.3 сая төгрөг буюу 2.3 хувиар давуулан бүрдүүлсэн байна.

Тайлант онд 25,944.9 сая төгрөгийн зардал батлагдаж гүйцэтгэлээр 23,302.8 сая төгрөгийг зарцуулснаас 11,937.9 сая төгрөгийг урсгал зардалд, 951.1 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, 363.4 сая төгрөгийг эргэж төлөгдөх зээлийн зардалд, 10,050.4 сая төгрөгийг дээд шатны төсөвт төвлөрүүлжээ.

8426050648

## Бусад асуудлын хэсэг

Аймгийн засаг даргатай байгуулсан 2025 оны гэрээний биелэлт нэгдүгээр хавсралт 6 зорилт 46 арга хэмжээ биелэлтийн дундаж 88 хувьтай, Хоёрдугаар хавсралт 5 зорилт 51 арга хэмжээ биелэлтийн дундаж 86,5 гүйцэтгэлтэй байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

## Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Х.БОЛДБААТАР

**Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл****2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

(төгрөгөөр)

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	1. ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	8,343,024.89	5,938,953.43
2	1.1.1 МӨНГӨН ХӨРӨНГӨ	4,635,165.68	3,084,125.79
3	1.1.3 АВЛАГА	842,688.08	1,095,314.37
4	1.1.4 УРЬДЧИЛГАА	2,454,168.4	1,174,381.3
5	1.1.5 БАРАА МАТЕРИАЛ	411,002.72	585,131.97
6	1.2 ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	18,265,108.56	21,894,180.19
7	1.2.2 ҮНДСЭН ХӨРӨНГӨ	18,265,108.56	21,894,180.19
8	1.2.2.02 Биет хөрөнгө	17,760,195.36	21,390,266.79
9	1.2.2.03 Биет бус хөрөнгө	504,913.2	503,913.4
10	1 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	26,608,133.45	27,833,133.62
11	2.1 НИЙТ ӨР ТӨЛБӨР	50,499.37	965,952.82
12	2.1.1 БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	50,499.37	965,952.82
13	2.1.1.03 Өглөг	50,499.37	965,952.82
14	2.2 ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	26,557,634.08	26,867,180.8
15	2.2.1 Засгийн газрын хувь оролцоо	26,557,634.08	26,867,180.8
16	2.2.1.01 Засгийн газрын оруулсан капитал	11,107,384.16	11,107,384.16
17	2.2.1.08 Хуримтлагдсан үр дүн	12,768,493.39	13,078,040.11
18	2.2.1.09 Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,681,756.53	2,681,756.53
19	2 ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	26,608,133.45	27,833,133.62

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

(төгрөгөөр)

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	25,976,062.89	30,176,410.45
2	1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО	19,989,960.06	21,963,267.66
3	1.1.1.03.1 Орлогын албан татвар	19,041,633.36	20,711,632.92
4	1.1.1.03.1.01 Хувь хүний орлогын албан татвар	19,678,581.81	21,650,148.8
5	1.1.1.03.1.02 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-636,948.45	-938,515.87
6	1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар	514,144.63	663,358.9
7	1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж	434,182.08	588,275.83
8	1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,094,765.46	8,213,142.79
9	1.1.1.04.3 Тусламжийн орлого	0.0	167,695.38
10	1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,891,337.37	0.0
11	1.1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	23,872,601.63	29,904,378.95
12	1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ	22,654,404.98	26,707,764.9
13	1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	13,733,438.23	14,878,126.26
14	1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,012,750.07	1,849,884.18
15	1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	249,196.22	229,131.71
16	1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,325,501.34	5,741,860.8
17	1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал	2,298,328.37	1,740,030.42
18	1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал	165,532.75	172,966.2
19	1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал	3,920.04	8,594.9
20	1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,106,802.71	1,920,007.87
21	1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал	3,571,406.73	3,215,650.17
22	1.1.2.01.3 ТАТААС	128,860	145,640.28
23	1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,792,106.75	11,683,998.36
24	1.1.2.02 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,218,196.66	3,196,614.05
25	1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	2,103,461.26	272,031.5
26	1.2.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.0	258.86
27	1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)	0.0	-258.86
28	1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	2,103,461.26	271,772.64

**2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (төгрөгөөр)**

№	Дансны нэр, төрөл	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө /өмч
1	1.1.1.1.1.1 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	24,445,855.91	24,445,855.91
2	1.1.1.1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	8,316.91	8,316.91
3	1.1.1.1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	24,454,172.82	24,454,172.82
4	1.1.1.1.7 Тайлант үеийн үр дүн	2,103,461.26	2,103,461.26
5	1.1.1.1 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	26,557,634.08	26,557,634.08
6	1.1.1 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	26,557,634.08	26,557,634.08
7	1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	37,741.39	37,741.39
8	1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	26,595,375.47	26,595,375.47
9	1.2 Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	32.69	32.69
10	1.7 Тайлант үеийн үр дүн	271,772.64	271,772.64
11	1 2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	26,867,180.8	26,867,180.8

**2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан (төгрөгөөр)**

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	1.1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	23,238,130.41	23,516,595.74
2	1.1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО	19,989,960.06	21,963,267.66
3	1.1.1.1.03.1 Орлогын албан татвар	19,041,633.36	20,711,632.92
4	1.1.1.1.03.1.02 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-636,948.45	-938,515.87
5	1.1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар	514,144.63	663,358.9
6	1.1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж	434,182.08	588,275.83
7	1.1.1.1.03.8.01 Бусад нийтлэг төлбөр, хураамж	78,346.28	33,831.68
8	1.1.1.1.03.8.02 Газрын төлбөр	355,832.6	554,444.15
9	1.1.1.1.03.8.03 Байгалийн нөөц ашигласны төлбөр	3.2	0.0
10	1.1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	372,558.97	1,553,328.09
11	1.1.1.1.04.1 Нийтлэг татварын бус орлого	372,558.97	330,107.61
12	1.1.1.1.04.3 Тусламжийн орлого	0.0	167,695.38
13	1.1.1.1.04.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	0.0	1,055,525.1
14	1.1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,875,611.38	0.0
15	1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	17,165,665.59	22,183,100.75
16	1.1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ	17,165,665.59	22,183,100.75
17	1.1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	8,243,541.84	10,355,000.64
18	1.1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,653,301.23	1,846,567.93
19	1.1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	201,630.81	229,025.31
20	1.1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,113,665.77	5,487,606.9
21	1.1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал	36,352.59	53,479.87
22	1.1.1.2.01.1.05 Нормативт зардал	199	1,067.6
23	1.1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал	175,282.25	172,700.8
24	1.1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал	3,920	8,504.9
25	1.1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,899,585.4	2,420,641.18
26	1.1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал	159,604.79	135,406.16
27	1.1.1.2.01.3 ТАТААС	128,860	145,240.25
28	1.1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,793,263.75	11,682,859.86
29	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	6,072,464.82	1,333,495
30	1.1.2.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	4,131,304.24	2,521,139.89
31	1.1.2.2.01 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,131,304.24	2,521,139.89
32	1.1.2.2.01.1 Дотоод эх үүсвэрээр	4,131,304.24	2,521,139.89
33	1.1.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-4,131,304.24	-2,521,139.89
34	1.1.3.2 ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	108,773.5	363,395
35	1.1.3 САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-108,773.5	-363,395
36	1.1 НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	1,832,387.08	-1,551,039.89
37	1.2 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,802,778.61	4,635,165.68
38	1 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	4,635,165.68	3,084,125.79

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

(төгрөгөөр)

Дансны код	Дансны нэр, төрөл	1. Төлөвлөгөө	2. Гүйцэтгэл
<b>1</b>	<b>3.1.01.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	<b>22,930,803.4</b>	<b>23,348,900.2</b>
<b>11</b>	<b>3.1.01.1.1 Татварын орлого</b>	<b>21,508,743.3</b>	<b>21,963,267.5</b>
110	3.1.01.1.1.1 Орлогын албан татвар	20,110,217.4	20,711,632.8
1100	3.1.01.1.1.1.1 Хувь хүний орлогын албан татвар	21,059,398.2	21,650,148.7
1101	3.1.01.1.1.1.2 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(949,180.8)	(938,515.9)
113	3.1.01.1.1.3 Хөрөнгийн албан татвар	502,709.5	663,358.9
118	3.1.01.1.1.8 Бусад татвар, төлбөр, хураамж	895,816.4	588,275.8
1180	3.1.01.1.1.8.1 Бусад нийтлэг төлбөр, хураамж	88,650.0	33,831.7
1181	3.1.01.1.1.8.2 Газрын төлбөр	807,166.4	554,444.1
<b>12</b>	<b>3.1.01.1.2 Татварын бус орлого</b>	<b>1,422,060.1</b>	<b>1,385,632.7</b>
120	3.1.01.1.2.1 Нийтлэг татварын бус орлого	366,535.0	330,107.6
123	3.1.01.1.2.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	1,055,525.1	1,055,525.1
<b>II</b>	<b>3.1.01.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>25,944,911.4</b>	<b>24,923,872.4</b>
<b>21</b>	<b>3.1.01.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>20,838,018.3</b>	<b>22,136,969.2</b>
210	3.1.01.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	10,575,478.5	10,318,869.1
2101	3.1.01.2.1.1.1 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,877,715.3	1,846,567.9
2102	3.1.01.2.1.1.2 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	234,676.8	229,025.3
2103	3.1.01.2.1.1.3 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,553,389.1	5,484,425.6
2104	3.1.01.2.1.1.4 Хангамж, бараа материалын зардал	46,741.6	39,581.2
2105	3.1.01.2.1.1.5 Нормативт зардал	1,725.0	1,067.6
2106	3.1.01.2.1.1.6 Эд хогшил, урсгал засварын зардал	190,391.5	172,117.8
2107	3.1.01.2.1.1.7 Томилолт, зочны зардал	9,923.6	8,504.9
2108	3.1.01.2.1.1.8 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,495,529.8	2,404,172.7
212	1.1.2.0.1.3 Татаас	192,321.50	145,240.20
2109	3.1.01.2.1.1.9 Бараа үйлчилгээний бусад зардал	165,385.8	133,406.1
213	3.1.01.2.1.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,070,218.3	11,672,859.9
<b>22</b>	<b>3.1.01.2.2 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>4,424,728.8</b>	<b>2,423,508.2</b>
<b>23</b>	<b>3.1.01.2.3 ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>682,164.3</b>	<b>363,395.0</b>
7	3 Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	3,014,108.0	(1,574,972.2)
4	4 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	4,635,165.7
5	5 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		3,060,193.5

**2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан**

(төгрөгөөр)

Дансны код	Дансны нэр, төрөл	2024.12.31	2025.12.31
<b>1</b>	<b>1.1.1.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	<b>628,715.37</b>	<b>177,495.38</b>
<b>12</b>	<b>1.1.1.1.1 ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>628,715.37</b>	<b>177,495.38</b>
12213	1.1.1.1.1.1.1 Нэмэлт санхүүжилтийн орлого	628,715.37	177,495.38
<b>II</b>	<b>1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>628,715.37</b>	<b>153,563.04</b>
<b>21</b>	<b>1.1.1.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>382,212.60</b>	<b>46,131.32</b>
210	1.1.1.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	90,647.35	36,131.32
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		3,181.24
2104	1.1.1.2.1.1.4 Хангамж, бараа материалын зардал	3,360.00	13,898.65
2105	Эд хогшил, урсгал засварын зардал		583.00
2108	1.1.1.2.1.1.8 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	31,368.45	16,468.43
2109	1.1.1.2.1.1.9 Бараа үйлчилгээний бусад зардал	55,918.90	2,000.0
213	1.1.1.2.1.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		0.0
2132	1.1.1.2.1.4.2 Бусад урсгал шилжүүлэг	291,565.25	10,000.0

22	1.1.1.2.2 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	246502.77	107,431.72
4	1.1.1 ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	0.00	23,932.34

**Гурав. Аудитын илрүүлэлт:**

Аудитаар нийт 65,355.8 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 65,355.8 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа<sup>1</sup>-г аудитын явцад залруулж, баталгаажуулав. Үүнд:

**Хоршоо хөгжүүлэх сангийн тайланд:**

- Авлагыг 46,149.2 мянган төгрөгөөр илүү илэрхийлсэн.
- Тайлант оны үр дүнгийн орлогыг 19,206.6 мянган төгрөгөөр илүү илэрхийлсэн.

Дээрх алдааг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-д “аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх” заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул тайланд залруулсан.

Аудитаар залруулагдаагүй алдаа, зөрчил илрээгүй тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

**Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:**

**4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдааны утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								тоо	Дүн	тоо	Дүн		
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
ХХС	Авлагыг санхүүгийн тайланд илүү илэрхийлсэн	1	46,149.20			1	46,149.2	1	52,500.0				
	Үр дүнгийн тайланд орлогыг илүү илэрхийлсэн.	1	19,206.2			1	19,206.2	1	19,206.2				
<b>ДҮН</b>		<b>2</b>	<b>65,355.8</b>			<b>2</b>	<b>65,355.8</b>	<b>2</b>	<b>65,355.8</b>		<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>

**Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТТЗ	1	1			1			
	<b>НИЙТ</b>	<b>1</b>	<b>1</b>			<b>1</b>			